

ХИЛИЙН БООМТ ДАХЬ ХИЛ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АСУУДАЛ

ISSUES OF IMPROVING THE LEGAL RELATIONS BETWEEN BORDER CONTROL AGENCIES AT BORDER POINTS

П.Батбаатар

Эрх зүйн магистр хөтөлбөрийн 7011 дүгээр дамжааны магистрант

Batbaatar P.

Master's student of the 7011th year of the Master of Laws program

*Хариуцлагатай зохиогч: Batbaatarp914@gmail.com

Хураангуй: Хилийн боомт дээр хил хяналтын байгууллагууд болох хилийн цэрэг, гааль-хорио цээрийн алба, болон тагнуул, цагдаа, боомтын захиргаа гээд маш олон байгууллагууд нэг дор хууль тогтоомжоор тодорхойлсон өөр өөрсдийн үндсэн чиг үүргүүдийг гүйцэтгэн ажилладаг.

Эдгээр байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааг “Хилийн боомтод мөрдөх журам” хэмээх бичиг баримтаар зохицуулж, хилийн боомтын дарга хэрэгжилтэд хяналт тавьж, удирдан зохицуулдаг. Хэдийгээр Монгол Улсын үндэсний болон хилийн аюулгүй байдлын төлөө гэсэн нэгэн том зорилгын төлөө ажилладаг хэдий ч бодит амьдрал дээр байгууллага байгууллагынхаа явцуу эрх ашгийг хамгаалан хамтран, харилцан ажиллах тал дээр “цоорхой” гардаг нь нууц биш билээ. Хилийн боомт дээр дэглэм, журмыг сахиулах, байгууллага хоорондын үйл ажиллагааг “Хилийн боомтын журам”-ын дагуу гуйвалтгүй хэрэгжүүлэх нь чухал болж байгаа юм.

Abstract: At border crossing points, various border control agencies — such as the Border Troops, Customs and Quarantine Services, as well as Intelligence, Police, and the Border Port Administration — operate together in accordance with their respective mandates as defined by law. The daily operations of these agencies are regulated by a document called the “Regulation on Procedures at Border Checkpoints”, the implementation of which is supervised and coordinated by the Head of the Border Port. Although all these agencies work toward the common goal of ensuring Mongolia’s national and border security, in practice, there are often “gaps” in cooperation and coordination, as each organization tends to prioritize its own institutional interests. Therefore, maintaining order and discipline at border crossing points and ensuring that inter-agency operations are carried out strictly in line with the “Border Checkpoint Regulation” is becoming increasingly important.

Түлхүүр үг: Хилийн боомт, боомтын дэглэм, журам, хилийн хяналтын байгууллагууд, харилцан ажиллагаа, боомтын журмын зөрчил

Key words: Border checkpoint, border regime, regulations, border control authorities, mutual cooperation, and violations of border checkpoint regulations.

Үндсэн хэсэг:

Хилийн тухай хуульд “Хилийн боомт гэж улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг хэлнэ (УИХ, 2016)” гэж заасан байдаг.

Хилийн хяналт шалгалтын байгууллагууд өөр өөрсдийн үйл

ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжтой, босоо удирдлагатайгаар үйл ажиллагаа явуулдаг боловч эдгээр хууль тогтоомж нь харилцан уялдаа холбоогүй, зарим тохиолдолд зөрчилтэй байгаа нь нэг ижил нөхцөлд ажиллаж байгаа байгууллага, албан хаагчдын харилцан адилгүй ажлын нөхцөл, цалин хангамж, хөнгөлөлт зэргээс харагдаж байна.

Хилийн боомтын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх, хилийн боомтын нэгдсэн бодлого, стандарттай болох,



МОНГОЛЫН
ДЭГЭР
ХАРИУЦАГЧИЙН
УНДСНЫ
АМЬСГАЛ




ХИЛ СУДЛАЛ

боомтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, боомтын дэд бүтцэд хамаарах автозам, ундны ус болон цахилгаан эрчим хүчний хангамж зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, боомт дээр үйл ажиллагаа явуулж байгаа хилийн хяналтын байгууллагуудын бүтэц, орон тооны асуудлаар бодлогын өөрчлөлт хийх, албан хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөлийг тэгш байдлаар шийдэх, тэдгээрийг нэгдсэн удирдлага, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангах үүрэг бүхий боомтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхааралдаа авч асуудлыг шийдэх, боомтын талаарх хуучин ойлголтыг халж, хүн ам төвлөрсөн, дэд бүтэц хөгжсөн, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжтой суурин газар боомт-хот болгон хөгжлийн цар хүрээг тэлэх зэрэг асуудлыг судлан үзэж, хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар хилийн боомтод ажилладаг төрийн байгууллагууд нь босоо удирдлагатай, нэгдсэн удирдлагагүй, нэгдмэл бодлогогүй, бие биеэс хараат бус, чиг чигээ харсан, нэгдмэл, харилцан ажиллагаа сул, эрх зүйн орчин нь тодорхойгүй байна. Үүнийг бид доор бүдүүвчээр харуулсан болно (Хилийн боомтод гарч байгаа зөрчил, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, 2020).

Харилцан ажиллагаа гэж хилийн хяналтын байгууллагууд хуулиар батлагдсан үндсэн чиг үүрэг, зорилгоо биелүүлэхийн зэрэгцээ хил орчмын аюулгүй байдлыг хангах, гадаадын иргэнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, хууль бусаар хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бүтээгдэхүүнийг илрүүлэх, таслан зогсоох, мэдээ мэдээлэл солилцох, боломжит бүх талийн техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх зэрэг багц арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж тодорхойлж болно.



Бүдүүвч. Хилийн боомтын хилийн хяналтын байгууллагуудын тогтолцоо

Өнөөдрийн оршиж буй боомтын нэгдсэн удирдлага, улсын хилээр нэвтрүүлэх хилийн хяналт, шалгалтын тогтолцоо нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний шаардлагыг бүрэн хангахад учир дутагдалтай, хилийн хяналт шалгалтыг явуулахад дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ харилцан адилгүй байгаагаас ялангуяа олон улсын

зэрэглэлтэй хилийн боомтуудын үйл ажиллагаанд хүндрэл учирч байна.

Хилийн боомтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталж, 2017 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж буй “Хилийн тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлд заасны дагуу “Боомтын үндэсний зөвлөл” бодлогын түвшинд, “Хилийн боомтын зөвлөл”

гүйцэтгэх түвшинд хэрэгжүүлэхээр хуульчилсан ч “Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам”, “Хилийн боомтод мөрдөх журам”-аас өөр баримт бичиг байхгүй байна. Хилийн боомтод мөрдөж буй журмын хэрэгжилтийг хил хамгаалах байгууллага сахиулдаг, боомтын барилга байгууламжийг гаалийн ариутгал, орчны ариун цэврийг хорио цээрийн алба хариуцдаг, боомтын хилийн хяналтын байгууллагуудыг нэгдсэн ойлголттой, ажлын уялдуулаг зохицуулдаг эрх, үүргийг ялгавартайгаар тусгасан албан ёсоор хүлээн зөвшөөрөх эрх зүйн баримт бичиг, /боомт/-ын тухай хууль одоогоор үгүйлэгдэж байна.


Хилийн хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдөж буй эрх зүйн хэм хэмжээний актуудын талаар судалсан бөгөөд өнөөдрийн байдлаар хилийн боомтод хилийн хяналтын байгууллагууд үйл ажиллагаандаа олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, үндэсний хууль, дүрэм, Засгийн газрын тогтоол, харьяа яамнуудын сайдын тушаал, агентлагийн даргын тушаал, журам, заавар зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 207 орчим эрх зүйн хэм хэмжээний актууд байгааг харьцуулан судалж, нэгтгэсэн болно.

Үүнээс үзэхэд хилийн боомтын үйл ажиллагаанд хил хамгаалах байгууллагаас нийт 92, гаалийн болон хорио цээрийн албанаас нийт 200, гадаадын иргэн харьяатын газраас нийт 101 хууль тогтоомжуудын мөрдөн ажиллаж байгаа нь

судалгаагаар харагдаж байна (Хилийн боомтод гарч байгаа зөрчил, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, 2020).

“Хилийн хяналтын байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын Хууль зүйн, Эдийн засгийн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын 2009 оны 13/15/12 дугаар тогтоолоор “Хилийн боомтын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулсан эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж, боомтын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, стандарттай болох асуудлаар бодлогын баримт бичиг, хөтөлбөр боловсруулж, холбогдох хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон;

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 01 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлээр “Хилийн боомтуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулсан эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль, тогтоомжийн болон төрөөс хилийн боомтын талаар баримтлах баримт бичгийн төсөл боловсруулж, 2010 оны 4 дүгээр сард багтаан Засгийн газарт оруулах”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд нарт даалгасан байдаг. (Хилийн боомтод бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв, 2012)



Монгол Улсын ОХУ-тай хиллэдэг хилийн авто замын боомтууд

ОХУ-ын хилийн боомтод хилийн хяналтын эрх бүхий байгууллагуудын ажилтнууд хууль тогтоох дээд байгууллагаас баталсан хууль тогтоомжуудыг үндсэн удирдлага болгож

дараах хэд хэдэн төрлийн хилийн шалгалтыг явуулна гэж заажээ. Үүнд: хилийн, гадаадын иргэний, эрүүл ахуй, хорио цээрийн, тээврийн, гаалийн, ургамал,



Дорноговь



ХИЛ СУДЛАЛ

мал амьтны гэсэн төрлөөр хилийн хяналт шалгалт явуулна.

Хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хангах, барилга байгууламж, тоноглож төхөөрөмжлөх зэрэг асуудлыг хариуцан ажиллах (Росгранстрой при МинТранспорта РФ) байгууллага ажиллаж байна. Энэхүү байгууллага нь чиг үүргийн хувьд Зам тээврийн яаманд харьяалагдаж, хилийн боомтын барилга байгууламж, техник төхөөрөмжөөр тоноглох, хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хойд хөрш ОХУ-ын хилийн боомтын тухай хуулийг судлан, тэдгээрийн эрх зүйн орчныг хэрхэн хуулиар зохицуулсан талаар мэдээллийг доор хураангуйлан орууллаа. ОХУ-ын хууль, тогтоомжууд нь ерөнхий зарчим, үзэл баримтлалаараа Тусгаар Тогтносон Улсуудын Холбооны /Союз Независимых Государств/ хууль, эрх зүйн хэм хэмжээнд ихээхэн нөлөөлдгөөрөө бусад улсуудын хууль, эрх зүйн орчноос ялгаатай байдаг байна. Оросын Холбооны Улсын “Хилийн боомтын тухай” хууль нь 9 бүлэг, 45 зүйлтэй (Ц.Ганболд, 2023).

Хуулийн “Нийтлэг үндэслэл” хэсэгт ОХУ-ын хилийн боомтын эрх зүйн орчныг тогтоох, хилийн боомтыг нээх, хаах, өөрчлөх, ашиглах, барилга байгууламжийг барих, өргөтгөх, нэмж төхөөрөмжлөх үеийн харилцааг зохицуулсан бөгөөд хилийн боомтын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг энэхүү хуулиар баталгаажуулна гэж заасан байна.

Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ОХУ-ын үндсэн хууль, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, ОХУ-ын олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг үндэслэн энэхүү холбооны хууль, эрх зүйн хэм хэмжээний актуудыг бүрдүүлэн хэрэгжүүлэх, хилийн боомтын талаар үүсэх харилцааг зохицуулахад хуулийн зорилт оршино гэдгийг тэмдэглэсэн байдаг. Энэ бүлэгт үйлчлэх хүрээ, эрх зүйн орчныг ямар хууль, гэрээ, хэлэлцээрийг үндсэн удирдлага болгон баримтлах, хуулийн хүрээнд хэрэглэн ашиглах мэргэжлийн нэр

томьёонуудын дэлгэрэнгүй тайлбарыг оруулсан байна. Мөн хилийн боомтуудын ангилал, зэрэглэл, төрлүүдийг хэрхэн тодорхойлох талаар тусгаж оруулсан бөгөөд хилийн гарцыг тогтоох асуудлыг ОХУ-ын олон улсын гэрээг үндэслэн, засгийн газрын тогтоолоор батлах, улс төр, нийгэм эдийн засгийн онцгой шаардлага, олон улсын гэрээ өөрчлөгдөх, боомтыг өөрчлөн төхөөрөмжлөх тохиолдлуудад мөн хилийн боомтын төрөл, ангилал, зэрэглэлийг өөрчлөх асуудлыг Засгийн газрын тогтоолоор тус тус зохицуулахаар зохицуулалт хийгдсэн байдаг. Хилийн боомтод үйл ажиллагаа явуулах хилийн хяналт шалгалтын байгууллагуудыг цохон тэмдэглэн, тэдний бүтэц, орон тоо, төсөв санхүүгийн байдлыг бусад хууль тогтоомжуудаар зохицуулна гэжээ.


Хилийн боомтын ажиллах журам, хил гааль болон бусад байгууллагуудын хяналт, шалгалт хийх ажиллагаа зэрэг хаалттай мэдээллээс бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэхээр зохицуулсан байна. Мөн мэдээллийг хэрхэн авах, ямар байдлаар олон нийтэд хүргэх асуудлыг тусгажээ. Хилийн боомтын мэдээллийг холбооны мэдээллийн санд цахим болон бичсэн байдлаар хадгалах, мэдээллийн санд боомтын ямар мэдээллийг байршуулахыг тодорхой болгосон.

“Хилийн боомтын журам” гэсэн дөрөвдүгээр бүлэгт хилийн боомтын журмын зорилго, агуулга, боомтод ажиллах иргэдийн хязгаарлалт, түүний эрх үүрэг, боомтод нэмэлт хязгаарлалт хийх журам, хилийн боомтоор улсын хил нэвтрэх үеийн зорчигч, тээврийн хэрэгсэл, эд бараа нэвтрүүлэх журам, хилийн боомтын журмын үйлчлэх хүрээ, хилийн боомтын журам үйлчлэх үеийн хил хязгаарыг тогтоох, аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулах журам, хилийн боомтын журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих асуудлуудыг хуульчлан баталгаажуулж өгчээ.

“Хилийн боомтод төрийн хяналт шалгалтыг явуулах” гэсэн наймдугаар бүлэгт хилийн хяналт шалгалтыг уг боомтод үйл ажиллагаа явуулж буй төрийн

байгууллагууд дараах дарааллаар хэрэгжүүлэхээр тусгасан.

Үүнд: Хил, гааль, эрүүл ахуй хорио цээр, мал аж ахуй, тээврийн хяналт шалгалт байхаар заасан байна.



БНХАУ-тай хиллэдэг Монгол Улсын хилийн авто замын боомтууд

Монгол, Хятадын хилийн боомтуудын байршил, төрөл, ангилал, нээх хугацаа, ажиллах хуваарийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2004 оны “Хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрээр тодорхойлон тогтоож, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулдаг ба өнөөдөр тус хэлэлцээрийн дагуу Монгол Улс, БНХАУ-ын хилд 13 хилийн боомт (1.5-д оруулав) үйл ажиллагаа явуулж байна (Ц.Ганболд, Хил хамааралтын ухаан, 2021).

БНХАУ нь хилийн боомтын талаарх хууль эрх зүйн орчныг Засгийн газрын тогтоолоор баталсан дүрмээр зохицуулан хэрэгжүүлдэг байна.

Тус дүрэм нь 6 бүлэг, 47 зүйлтэй.

Дүрмийн “Ерөнхий бүлэг” хэсэгт БНХАУ-ын бүрэн эрх, аюулгүй байдал болон нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг хилээр нэвтрэхэд нь таатай нөхцөлийг бүрдүүлэхэд гол зорилго оршино.

БНХАУ-ын хилээр нэвтрэгсдэд тавих хяналт шалгалтыг тус улсын НАХЯ хариуцна гэж заажээ.

Хилийн шалган нэвтрүүлэх боомтыг усан, агаарын, авто болон төмөр замын буудал зэрэг хилийн нээлттэй гарцуудад байгуулна гэж тусгасан байна.

Хилийн боомтод эрх олгогдсон энэхүү байгууллагын үүргийг тодорхой тусгасан ба хуулийн хүрээнд үүргээ гүйцэтгэж буй ШНБ-ын ажилтанд ямар ч

байгууллага, хувь хүн саад хийх эрхгүй хэмээн бүрэн эрхийг тодорхойлж өгсөн байна.

“Зорчигчдод тавих хяналт шалгалт” гэсэн хоёрдугаар бүлэгт зорчигчийг хэрхэн улсын хилээр нэвтрүүлэх, ямар баримт бичгээр улсын хилээр нэвтрэх, ямар тохиолдолд улсын хилээр нэвтрэхийг хориглох, усан боомтод хоногдосон үед хөлгийн болон багийн бүрэлдэхүүн ямар журмаар эрэг дээр гарч болох, ямар тохиолдолд зорчигчдын биед үзлэг хийх зэрэг журмыг тусгасан байна.

“Тээврийн хэрэгслийн хяналт шалгалт” гэсэн гуравдугаар бүлэгт тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалт хийх журам улсын хилээр нэвтрүүлэхгүй байх тохиолдлууд зэргийг тодорхой заажээ.

“Гар тээш болон ачаа барааны шалгалт” гэсэн дөрөвдүгээр бүлэгт ШНБ-нь улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үүднээс хилээр нэвтрэх буй зорчигч тээврийн хэрэгсэлд ачиж яваа бараанд нь хэсэгчилсэн шалгалт явуулах эрхтэй. Зорчигчийн гар тээш, ачаа бараанд хуулиар хоригдосон зүйл илэрсэн тохиолдолд холбогдох хууль, засаг захиргааны журмын дагуу хариуцлага хүлээлгэх, зэвсэг, галт хэрэгсэл авч явах тохиолдолд холбогдох хууль, засаг захиргааны заавар, журмын дагуу зөвшөөрөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлэх журмыг тус тус тусгаж өгсөн байна.



Дорноговь



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙ
ХИЛ СУДЛАЛ

“Хүлээлгэх хариуцлага” гэсэн 5 дугаар бүлэгт захиргааны арга хэмжээ буюу торгуулийг хилийн боомтын дарга, орлогч нарыг хариуцан оногдуулах эрх үүргийг олгосон байна. Ямар тохиолдолд торгууль оногдуулах, мөнгөн дүнг тодорхой зааж оруулсан байдаг байна.

“Хавсралт” гэсэн 6 дугаар бүлэгт дипломат эрхтэй гадаадын иргэдийн эрх зүйн байдал, өөрийн орны иргэдийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг хэрхэн баримтлах, дүрэм ашиглагдах зарим нэг нэр томьёоны тайлбар, дүрмийн үйлчилж эхлэх хугацааг заажээ.

НАХЯ-нд харьяатай хилийн боомтын асар буюу манайхаар хилийн боомтын захиргаа нэртэй байгууллага байдаг байна. Энэ нь хилийн боомтын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, боомтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, дэд бүтэц зэргийн ашиглалтыг сайжруулах, өргөтгөх, шинээр барьж байгуулах асуудлыг хариуцан бие даан үйл ажиллагаа явуулдаг. Уг байгууллагын харьяа салбарууд хилийн томоохон боомт байрласан хотуудад үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Боомтын сэргэлтийн Үндэсний хороо нь ОХУ-ын Ространица, БНХАУ-ын Боомтын асар зэрэг байгууллагуудтай ижил ажил үүргийг гүйцэтгэх буюу хилийн боомтын хөгжил, дэд бүтцийн бүтэн байгуулалтын ажлыг хариуцдаг хэдий ч боомт дээрх хил хяналтын байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох хандлагатай нь учир дутагдалтай.

Стратегийн түвшинд харах болсон боомтын үүргийг зөв бодлогоор шуурхай удирдах алсын хараагаа Боомтын Үндэсний хороо боловсруулжээ. Боомтуудыг хөгжлийн бие даасан хэлбэрт оруулах энэхүү стратегийг 5Э хэмээн томъёолоод байна.

Тодруулбал, Эрх зүйн орчныг тодорхой болгох, боомтуудыг үйл ажиллагаа, бүс нутгийн оролцоогоор ангилж Эрэмбэлэх, боомтууд дээр болж буй үйл явдлыг Эзэнтэй хариуцлага тооцох бололцоотой болгох, боомтуудын үйл ажиллагаа явуулах “Эдэлбэр газар”-ын

асуудлыг бүрэн шийдвэрлэх, ингэснээр боомт нь Эдийн засагт боомилгогч биш хөгжлийн зүтгүүр болно гэсэн томъёолол юм. Үүний тулд боомтын хууль эрх зүйн орчныг шинэчилж, Хилийн боомтын тухай хууль, боомтын нийтлэг журмын шинэчилсэн төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж байна. Хэлэлцүүлэн буй төслөөр боомт нь эдэлбэр газартай, дүрэм журам, зорилготой, аж ахуйн тооцоот ашгийн төлөө хуулийн этгээдээр удирдуулсан, бусад орны боомттой олон улсын худалдаанд эзлэх байр сууриар өрсөлдсөн, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагааны байгууллага байх юм гэжээ.

Дүгнэлт

1.Хилийн боомтын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд “Хилийн боомтын тухай хууль”, “Хяналт шалгалтын тухай хууль”-ийг боловсруулан батлуулж мөрдөх;

2.Хилийн боомтын үйл ажиллагааг удирдах, зохицуулах харилцан ажиллагааг уялдуулах /нэг цэгт/ төвлөрүүлэх;

3.Боомтын үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсын ХЗДХЯ, Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яам, /Боомтын захиргаа, чөлөөт бүсийн захиргаа/ зэрэг олон байгууллагууд хэрэгжүүлж байгаа нь боомтын удирдлага, аюулгүй байдал, хөгжлийн асуулалд хүндрэл учруулах;

4.“Хилийн боомтод мөрдөх журам”-ын стандартыг бий болгох;

5.Хилийн боомтын үйл ажиллагааг хуулиас давсан олон журмуудаар бус хуулиар зохицуулдаг болох, олон журмыг нэгтгэх, багасгах, давхцалыг арилгах зэрэг болно.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

УИХ. (2016, 12 28). Монгол Улсын Хилийн тухай. Retrieved from www.legalinfo.mn

(2012). Хилийн боомтод бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв.

(2020). Хилийн боомтод гарч байгаа зөрчил, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.